

**“МОНГОЛ-ОРОСЫН ХАРИЛЦАА БАРИМТ БИЧГҮҮД  
1991-2004 ОН” Баримт бичгийн эмхэтгэл  
444х. УБ, 2006**



Энэхүү эмхтгэл нь Монгол-Оросын харилцааны шинэчлэл, хамтын ажиллагааны эрх зүйн үндэс, нийтлэг зорилтуудыг тусгасан 1991-2004 оны үеийн олон арван баримт бичгийг багтааж ихэнхийг нь анх удаа нийтэлж уншигч олны сонорт хүргэж байгаагаар онцлог юм. Уг эмхтгэл хоёр үндсэн хэсгээс бүрдэж байна. Нэгдэх хэсэгтээ: 1991 оноос хойш хоёр орны харилцааны мөн чанар, агуулга, эрх зүйн үндэс, арга механизм хэрхэн өөрчлөгдөн хөгжиж ирснийг харуулсан төр, засгийн дээд удирдлагын түвшинд Ерөнхийлөгч нарын, Парламент, Засгийн газрын хооронд байгуулсан

гэрээ, хэлэлцээрүүд, салбарын яам газруудын хамтын ажиллагааны хэлэлцээрүүд, хамтарсан комисс, байгууллагууд, тухайлбал, Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах Засгийн газар хоорондын комиссын хуралдаанууд болон бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны дэд комиссын хуралдааны Протоколлууд зэрэг удирдамжийн чанартай, хамтын ажиллагааны үндэс болох баримт бичгүүдийг үндсэнд нь багтаажээ.

Хоёрдох хэсэгтээ: хоёр улсын бүс нутаг, хил орчим, субъект хоорондын шууд харилцаа, хамтын ажиллагаанд холбогдох баримт бичгүүд, түүний дотор Монголын аймгууд, ОХУ-ын Бүгд найрамдах улсууд, муж, хязгаар, автономит тойргуудын хооронд байгуулсан гэрээ хэлэлцээр, орон нутгийн төлөөлөгчдийн ажлын айлчлалууд, аж ахуй, соёлын хамтарсан байгууллага газруудын ажил хэргийн холбогдол бүхий арвин их баримтаас сонголт хийж зарим чухлыг авсан байна. Үүний хамт хоёр улсын олон нийтийн байгууллагууд, залуучууд, эмэгтэйчүүд, оюутны, өргөн олныг хамарсан соёл иргэншлийн, хүмүүнлэгийн үнэт зүйлийг дээдэлсэн олон талт үйл ажиллагааг тусгасан мэдээллийн нэлээд материал оржээ.

Баримт бичгүүдийг хоёр хэсэг тус бүрд он цагийн дарааллаар тус тусад нь эрэмбэлэн нэгдэх хэсэгтээ 37, хоёр дахь хэсэгтээ 67, нийт 104 баримт бичгийг багтаажээ.